

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ГУМАНИЗАЦИ БА ҮЛ ХҮЧИРХИЙЛЭЛИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ АСУУДАЛД

Д.Ганболд

ШУТИС. Хүмүүнлэгийн ухааны сургуулийн

Түлхүүр үг: Монголын нийгмийн өнөөгийн нийгэм-улстөрийн байдлын чиг хандлага. Нийгмийн харилцааны зөрчил. Нийгмийн харилцааны гуманизацийн бодит шаардлага. хүчирхийлэлээс ангижирсан нийгмийн эрүүл орчинг бий болгох нийгмийн бодит хэрэгцээ. Үл хүчирхийлэлийн ёс зүйн асуудал. Үл хүчирхийлэлийн онолын үзэл баримтлалууд.

Энэхүү өгүүлэлийг бичихэд хүргэсэн гол шалтгаан нь, нэг талаас, нийгмийн шилжилтийн үед сүүлийн 15 жилд, тухайлбал 1997 оны “Ашигт малтмалын тухай хуулиас” эхлэн ардчилалаар дөрөөлж улс төрийн намуудаар дамжин өндөр албан тушаалд дэвшиж гарсан улс төрийн намуудын тодорхой бүлэглэлийн балгаар төрийн статусыг алдагдаж, шилжилтийн үеийн эдгээр “тохиолдлын” хүмүүс ард түмний үндсэн эрх ашгийг уландаа гишгэн, тэдний зүгээс явуулж буй зохисгүй үйл ажиллагаагаар ард түмний өмч хэмээн нэгэнт хуулинд тунхаглан зарлагдсан байгалийн баялаг гадаадынханд үнэгүй шахам наймаалагдаж, дундаас нь ашиг унагадаг авилгалын сүлжээ үүсч, нийгмийн ардчилсан үйл явц мухардмал байдалд орох аюул тулгарч байна. Цаашдаа энэхүү төрийн албан ёсны дээрмийн хэлбэрт шилжсэн балмад үйл ажиллагаа нийгмийг ямар аңгал руу хүргэх нийгмийн хариуцлагын асуудлыг өөртөө хүлээх ямар ч улс төрийн нам өнөөгийн Монгол Улсад алга. Иймд өнөөдрийн Монголд бий болсон нийгмийн тогтворгүй байдал улс орны эдийн засгийг сүйрлийн ирмэгт авчирч, олон түмний амьдралыг доройтуулан, эрүүл саруул ухаанаар эрхээ хамгаалан тэмцэн гудамжинд жагсаал цуглааны хэлбэрээр дургүйцлээ илэрхийлэхээс эхлэн тэмцлийн нарийн зохион байгуулалтанд орох хүртэл турхирсан эрх барьж буй намуудын баримталж буй увайгүй байр суурь нийгэмд болж буй үйл явцын гол сэдэлт, шалтгаан болж байгаа байдал, нөгөө талаас монголын нийгэмд хүчирхийлэл, аюул занал бүү нүүрлээсэй гэсэн санааны улмаас нийгмийн харилцаан дахь гуманизацийн асуудал өнөөдөр бидэнд юунаас ч илүү чухал хэрэгтэй, хүчирхийлэлээс ангижирсан нийгмийн эрүүл орчинг бий болгох нь ус агаар мэт үгүйлэгдэж байгааг философийн байр сууринаас тайлбарлах нь чухал гэдгийг юуны өмнө онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Сүүлийн үеийн гуманитар ном зохиолуудад "хүчирхийлэлээс ангижрахуйн ёс зүйн" асуудал улам ихээр тусгагдах болсон нь 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхээр олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт, ардчилсан эхлэлүүд, улс төрийн шинэ харилцаатай холбоотой нь зүй ёсны хэрэг юм.

Хүн төрөлхтний түүхийн ямар ч үеийг авч үзсэн хүчирхийлэлгүй байсан үеийг олоход үнэхээр бэрх юм. Ийнхүү хүчирхийлэлийг урьд өмнө байсан, одоо ч байгаа, цаашид ч байх болно хэмээн мөнхжүүлэх аястай үзэл бодолтой санал нийлэх ёсгүй хэмээн үзэх нь нийгмийн харилцааг нэн даруй гуманизацижуулах хэрэгтэй гэсэн өнөөгийн шаардлагатай зүй ёсоор нийцэж байгаа билээ. Хүчирхийлэлийг хүн төрөлхтөн даван туулж, түүнийг нийгмийн хүрээнээс зайлуулах арга замыг эрж хайж олох эрүүл ухаан санаа хүн төрөлхтөнд бий гэдэгт олон судлаачид итгэж судалгааны эрэл хайгуулаа үргэлжлүүлсээр байна. Хүчирхийлэлийг нийгмийн амьдралын хүрээнээс зайлуулахгүйгээр энх тайван амар жимэр амьдрах тухай зүүдлэхийн ч хэрэггүй бизээ. Хүчирхийлэлийг нийгмийн хүрээнээс зайлуулахын тулд хүчирхийлэл гэж юу болохыг философийн шинжлэх ухааны үүднээс нарийвчлан үзэх шаардлагатай.

Ердийн танин мэдэхүйн түвшинд хүчирхийлэл нь бие махбодийн хувьд хүчирхийлэх гэсэн утгатай байдаг. Гэхдээ энэ утга нь хүчирхийлэл гэдэг олон талт утга бүхий зүйлийн зөвхөн нэг нь гэдгийг анхаарах нь чухал. Үүнээс гадна хүчирхийлэлийг дотор нь айж эмээснээс, ажилгүйдэхээс, эдийн засгийн янз бүрийн дарамтнаас, мөн түүнчлэн мөлжлөгөөс болж үйлдэгдсэн гэсэн хэлбэрүүдэд хуваан авч үздэг. Мөн түүнчлэн тоталитар засаглал хүмүүсийг өөрийнхөө оршин тогтноход үг дуугүй байдаг зарц, дарангуйлах төрийн тогтолцоо нь "эрэг боолтын" үүрэг гүйцэтгэдэг автомат-хүмүүс болгон хувиргадгийг ч хүчирхийлэлийн хэлбэрт багтаан авч үзэх нь зайлшгүй юм. Үүнтэй уялдаж хүний амь насанд учрах аюул занал, аллага, эд хөрөнгийг хууль бусаар хураан авах үйлдэл, дээрэм тонуул, тамлал зовлон зэргийг хүчирхийлэл хэмээн үзэх ёстой.

Оросын философич А.А.Гусейнов хүчирхийлэл бол хүний бие махбодийн болон моралийн чөлөөт байдлын орон зайг дарамтлан хавчиж зориуд санаатай үйлдэж буй хязгаарласан шинжтэй үйл явц мөн хэмээн тодорхойлжээ.

АНУ-ын А.Эйнштейний Институтын ерөнхийлөгч Дж.Шарп улс төрийн

хүчирхийлэлийн талаар нарийвчилсан судалгаа хийж, хүчирхийлэлийн энэ хэлбэр нь улс төрийн үйл ажиллагааны зорилго ба үр ашгийн талаар алдаатай төсөөлөл, өстөн дайсны дүрийг зохиомлоор бүтээж түүнийгээ дарж устгах, улс төрийн хамгийн их ашиг хонжоо олохын төлөө эрмэлзэхдээ нийгмийн арми, цагдаа, шорон, засан хүмүүжүүлэх газрууд зэрэг институтжсэн нэгжүүдийг ашигладаг хэмээн дүгнэсэн нь хуучин социалист орнуудын түүхэнд хар толбо болон үлдсэн 1930-аад оны сүүлчийн болон дэлхийн II дайны дараах хэлмэгдүүлэлт, түүгээр ч үл барам өнөөгийн ардчилсан орон болон хувирсан гэх Монгол улсад МАХН МУ-ын төр, УИХ, Засгийн газрыг 2000 оны сонгуулиас хойш үнэндээ бараг дангаараа удирдаж, Английн Ерөнхий сайд Тони Блэйрийн хэлсэнчлэн, тэд өөрсдийгөө коммунист биш гэж аман дээрээ ярьдаг боловч коммунистууд хэвээрээ гэдгээ мэддэггүй нь хамгийн аймшигтай гэдгийг нотолсон мэт сүүлийн үед төр засгийн дээд түвшин дэх авилгалыг таслан зогсоож монголын нийгэмд нийгмийн жинхэнэ шудрага ёсыг тогтоохын төлөө олон түмний зүгээс явуулж ирсэн янз бүрийн хөдөлгөөн тэмцэлд төр засгийнхны зүгээс ямар байр сууринаас хандаж байгааг улс төрийн хүчирхийлэлийн өвөрмөц шинэ хэлбэр яах аргагүй мөн хэмээн үзэхээс өөр аргагүй юм. Төр засгийн өндөр албан тушаалтнууд тусгай албаны ажилтнууддаа **зэвсэгтэй байлдааны өндөржүүлсэн бэлэн байдал** зарлаж байсныг Монголын чөлөөт ахмадуудын холбооноос санаачлан 2006 оны хавар Төрийн ордны хойт талд болсон эсэргүүцлийн цуглааны үед энгийн хүний хувцастай хүний дүр бүхий урт цув өмсөж түүн дотроо автомат буу нуун далдалсан тусгай албадын залуусыг харахад хангалттай байв. Хэрэв энгийн жагссан иргэдийн эсрэг галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд түүнээс үүдэн гарах хор хохиролын хариуцлагаас мултрахын тулд өөрийнхөө статусыг алдаж олон түмний нүүрэн дээр нэр сүрээ алдсан өнөөгийнх шиг төр ямар ч аргаар зайлсхийж хэн нэгнийг гэм буруутан болгодог сонгодог аргаа хэрэглэн хүчирхийлэх нь дамжиггүй юм. Энд дээр дурьдсан А.Эйнштейний Институтын ерөнхийлөгч Дж.Шарп хийсэн дүгнэлт бодит байдалтай үнэхээр дүйцэж байгаад гайхах хэрэггүй. Ер нь хэлмэгдүүлэлт нь олон хүнийг хоморголон баривчилж бие махбодийнх нь хувьд устгадаг нь аймшигтай бөгөөд хүний эрх чөлөөг уландаа гишгэж, хүний эрхийг бүдүүлгээр зөрчин, нийгмийн ёс суртахууны үнэт зүйлсийг устгадаг нь нийгэмд учруулдаг гол хохирол юм.

Эдүгээ түүхэн дэх хүчирхийллийн үүргийн талаар марксизмын

баримталж байсан үзэл үнэн хэрэгтээ түүхэн үйл явцыг субъектив аргаар түргэтгэх гэсэн эрмэлзэлд олон түмнийг турхирсан явдал болсон гэсэн дүгнэлтийг олон судлаачид хийж байна.

Иймд ямар ч эрхэм дээд зорилго, түүхэн зайлшгүй байдал байсан ч хүчирхийлэлийг тодорхой хэмжээгээр зөвшөөрнө гэдэг бол өнөөгийн хүмүүнлэг нийгмийг байгуулахаар нийтээр тэмүүлэн эрмэлзэж буй үед байж боломгүй балмад зүйл гэхээс өөрөөр хэлэх үг олдохгүй гэдгийг тайлбарлах нь илүүц биз. Буддын философид хүчирхийлэлээс ангижрахуй гэсэн нэр томъёог албан ёсоор хэрэглээгүй ч хүн бусдыг огоорч хувиа хичээх, бүдүүлэгтэх, уур хилэн гаргах, шуналтах, өөрөөр хэлбэл сөрөг "би"-г даван туулсан үед төгс төгөлдөр болж чадна хэмээн сургадаг нь хүчирхийлэлгүй байх бүрэн дүүрэн боломжийг илтгэж байдгийг хүмүүс бэлхэнээ санах бизээ.

Лев Толстой, Махатма Ганди нар хүчирхийлэлээс ангижрахуйн гүн ухааны үзэл санааг сурталчиллагчдыг ивээн тэтгэж байсан хоёр түшиг багана байсан гэдгийг тэдгээрийн олон бүтээлүүд бэлхэнээ нотолдог. Махатма Ганди европын иргэншлийг тал бүрээс нь судлаж, европын эдийн засгийг гуманицажуулах бус, харин ч хүмүүн төрөлхтөнд гүнзгий төөрөгдөл үүсгэсэн өрнөдийн иргэншлээс татгалзахыг тухайн үедээ санал болгож байв. Өрнөдийн иргэншил: Энэ бол нүсэр том хотууд, автомашинууд, парламент, нийгмийн байгууламжлагдсан бүтэц, зохиомол орчин. Эдгээр нь бүхэлдээ нийлээд хүмүүсийг материалын хувьд тансаг болгоход чиглэгдсэн. Энэ бүхэн нь аяндаа хүчирхийлэлийг төрүүлдэг гэсэн Махатма Гандийн санаа ерөнхийдөө Лев Толстойнхтой дүйцдэг.

Хэрэв иргэншлийг түүхэн үйл явц хэмээж, энэ нь орчин үеийн өрнө, дорнын хувилбарыг үүсгэхэд хүргэсэн гэх аваас орчин үеийн иргэншил бүхэлдээ хүчирхийлэлтэй зууралдсан гэж үзэхээс өөр аргагүй. Орчин үеийн нийгмийн чөлөөт байдлын орон зайн тулгуур үндэс нь хүнд бие махбодийн болон материаллаг хохирол учруулах санаа бүхий хүчирхийлэл мөн гэсэн дүгнэлтийг хийж болно.

Ер нь нийгмийн харилцаанд хүчирхийлэл яагаад ингэтлээ их шингэсэн юм гэсэн асуулт аяндаа заавал гардаг. М.Гандийн үзлээр хүмүүс өөрсдийнхөө оршихуйг бие махбодийн болон материаллаг тансаглалтай холбож ойлгон ирсэн. Харин К.Марксынхаар бол эдгээр баялаг нь хүмүүст чамлалттай өгөдсөн тул пролетаричууд хувьсгалаар өөрсдийн диктатурыг (хүчирхийлэлийг гэж унших- Д.Г) тогтоон шийдвэрлэх учиртай гэдэг.

Хүмүүсийн бие махбодийн тансаглалд ханах хязгаар гэж байхгүй учраас дутуу хүтүүгийн нөхцөлд зохицуулан оюун ухаанаар амьдрахад суралцах ёстой гэж М.Ганди сургасан нь буй. Энэ тухай К.Маркс үзэхдээ: Хүн материаллаг баялагаар бүрэн хангагдсан үед түүний хуваарилалтаас болж хүмүүсийн дунд зөрчил гарах учиргүй гэжээ.

Ерөнхийдөө муу юм, хүчирхийлэл бүхэн материаллаг үнэт зүйлсийн хүрээтэй холбоотой гэдэг дээр дээрх сэтгэгчид санал нийлдэг. Энэ замаас хүмүүс шууд татаглзах ёстой хэмээн М.Ганди үзсэн байхад, К.Маркс энэ замыг хурдан туулж, ардаа эгнэгт орхих нь зүйтэй гэжээ.

Энэ хоёрын хэнийх нь зөв бэ? Ганди дээрх асуудлыг моралийн аргаар, маркс прагматик байдлаар шийдэхийг санал болгожээ. Энэ асуудлын шийдэл нь түүхэн үйлдэл ба моралийн сонголт, иргэншил ба моралийн зөрчилт байдлын холбоог бүрмөсөн таслан зогсооход оршиж байгаа нь ойлгомжтой. Үүнийг орчин үеийн нийгмийн өмнө оршиж буй дилемма гэлтэй. Хэрэв Марксынх зөв гэж үзвэл хүн төрөлхтөн Гандийн хэлсэн үнэнийг хэзээ ч олж мэдэхгүй. Хэрэв Гандийн зөв гэж үзвэл хүн төрөлхтөн ямар ч атугай "хүчирхийлэлгүйн давчуу замыг" дардан шулуун болгох нь дамжиггүй.

Олонхи судлаачид хүчирхийлэлгүй байхуйг ойлгохдоо бие махбодид дарамт үзүүлэх хэрэгслийг хэрэглэхгүй байх нь идэвхитэй тэмцлийн хэрэгсэл мөн гэдэг дээр санал нийлдэг. Гэхдээ хүчирхийлэлээс ангижрахуйн үзэл баримтлал бүрэн боловсрогдох ёстой гэдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Идэвхтэй тэмцлийн хэлбэр нь пацифизм бус, харин энэ нь Торо, Ганди, Кинг нарын үеэс практик болж ирсэн хүчирхийлэлээс ангид байхын эсэргүйцэхүй юм. Германы философич Г.Занер: "шүүмжлэл, суртал нэвтрүүлэг, жагсаал, ажил хаялт зэрэг нь хууль ёсны зүйлүүд. Эдгээр нь эсэргүйцэхүйд хамаарахгүй... Эсэргүйцэхүй гэдэг нь шууд утгаараа иргэний үл захирагдах ёс юм" гэж тайлбарлажээ.

Сүүлийн үед энэ асуудал судалгааны нэлээд материалд тусгалаа олсон бөгөөд эдгээрээс дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд: Иргэний үл захирагдах ёс гэдэг бол...

- ✓ Эрх зүйт төр ёсны үеийн эсэргүйцэхүйн ердийн буюу хэвийн хэлбэр;
- ✓ Хуулийг өөрчлөн төр засгийн бодлогын алдааг засах;
- ✓ Энэ бол легал бус үйлдэл;
- ✓ Ардчилсан бус төр ёсны үед дотоод эсэргүйцэхүй;

- ✓ Идэвхтэй дуугүй эсэргүйцэхүй;
- ✓ Хуулийн шийтгэл хүлээх үйлдэл биш;
- ✓ Ардчилал бол нийтийн улс төрийн эсэргүйцэхүй явагдах нийгмийн орчин;
- ✓ Ардчилалын үеийн улс төрийн эсэргүйцэхүй бол хүний эрх мөн гэх зэрэг нийтлэг үндэслэлүүд боловсрогдож байна.

Хүн хүчирхийлэл, шудрага бус юманд хэрхэн хандвал зохих вэ? гэсэн асуулт заавал гардаг. Энэ асуултын хариулт нь: Хүн дуугүй, идэвхгүй байр суурь баримтлах ёсгүй. Хэрэв ийм байр суурьтай байвал дээрх зүйлүүдийг дэмжиж байгаа буюу хүчирхийлэлийг тодорхой байдлаар өөртөө агуулж байгаа гэсэн үг юм. Дуугүй байхад хүргэдэг хэд хэдэн шалтгаан байдаг. 1-рт, одоогийн тав тухаа алдахгүйн тулд, 2-рт, асуудалд нүдэн балай чихэн дүлий байх буюу хүч мөхөсдөх, 3-рт, айж балмагдах. Айж балмагдах нь хүчирхийлэгчдийн дөрөөлдөг зүйл гэдгийг ямагт санах ёстой. Иймээс идэвхгүй сул байдал гэдэг бол хүчирхийлэлээс ангид байхын эсэргүйцэхүйтэй ямар ч холбоогүй зүйл юм.

Хүчирхийлэлд хүчирхийлэлээр хариу барьж болох уу? Хүчирхийлэлийг хүчирхийлэлээр хариулна гэдэг нь адгуусны ертөнцөд адгуус өөрийнхөө бүрэн бүтэн байдлыг авч үлдэхийн тулд хийдэг үйлдэл. Хүн үүнийг хуулбарласнаар өөртөө араатнаас ялгагдахгүй инстинктийг бий болгож байна гэсэн үг. Шудрага бус зүйлээс өөрийгөө хамгаална гэдгийг амьдралд тэмүүлсэн үйл явц хэмээн ойлгох юм бол хүн үүнд ухаалгаар хандах ёстой. Ухаалгаар хандана гэдэг нь хүчирхийлэлгүй тэмцлийг явуулах зохистой хэлбэрийг сонгож олно гэсэн үг.

Чухамдаа зохистой хэлбэр гэдгийн ерөнхий утга нь хүчирхийлэлгүй хэрэгсэл мөн. Энэ бол хүний жинхэнэ мөн чанараас улбаатай учраас үүнийг хэрэглэх нь хүн өөртөө гүн хүндэтгэл үзүүлж, хүчирхийлэлийн хэлхээг таслан зогсоож байгаа явдал юм. Хүчирхийлэлгүй тэмцлийн гол зорилго нь хүчирхийлэл үйлдэгчдэд өөрсдийнх нь бурууг ойлгуулах, зайлшгүй үзэл бодлоо шинэчлэхэд хүргэж аль болохоор шудрага ёсыг бий болгох бололцоог өрнүүлэх явдал юм.

Аливаа зөрөлдөөн мөргөлдөөнийг хүчирхийлэлийн аргаар шийднэ гэдэг нь хэн нэгэнд хүндрэл зовлон, үхэл учруулж, гай тохооно гэж үзэх юм бол хүчирхийлэлгүй тэмцэл нь үйлдлээс гарч болох бүх үр дагаварыг өөрөө хариуцана гэсэн утгаараа ч гуманист шинжтэй үйлдэл юм.